# ХҮН АМ, ӨРХИЙН БҮРТГЭЛИЙН ДЭВТРИЙГ ХӨТЛӨХ НЬ

ЧОЙБАЛСАН ХОТ

2015.06.26

# ХҮН АМ, ӨРХИЙН БҮРТГЭЛИЙН ДЭВТРИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

I. Хаягийн хэсэг;

II(А). Өрхийн гишүүдийн үндсэн бүртгэл;

II(Б). Өрхийн гишүүдийн бүртгэл;

III. Өрхийн бүртгэл;

- Сууцны нөхцөл
- Өрхийн аж ахуй

# АГУУЛГА

- Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн ерөнхий мэдээлэл
- Хүн ам, өрхийн үзүүлэлтийг нөхөхөд анхаарах зүйлс

# ХҮН АМ, ӨРХИЙН БҮРТГЭЛИЙН ДЭВТРИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- Асуултыг дарааллаар нь асуух;
- Асуултын хариултаас сонгох;
  - Жагсаасан хариултаас зөвхөн нэг хариултыг тэмдэглэх;




  - Жагсаасан хариултын урд талд тэмдэглэгээ хийх нүд байвал нэг болон түүнээс олон хариултыг тэмдэглэх боломжтой;



# ХҮН АМ, ӨРХИЙН БҮРТГЭЛИЙН ДЭВТРИЙН ХӨТЛӨЛТ

- Хариулагч зөвхөн нэг хариулт сонгох асуултад олон хариулт өгсөн тохиолдолд лавлан асууж нэг хариултыг авах;

- Өрхийн гишүүдийн бүртгэлийн тодорхой нас зааж асуухыг сайтар анхаарах;

# ӨРХ

Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг оруулна.

Өрхийн гишүүд :

- Гэр бүл
- Ураг төрөл болон хамаатан садны холбоотой хүмүүс
- Хамааралгүй хүмүүс байж болно.



ХАӨМС-нд тухайн баг, хороонд **6, түүнээс дээш сар**ын хугацаатай оршин сууж байгаа өрхийг бүртгэнэ.

# ӨРХИЙН БҮРТГЭЛД ГАРЧ БУЙ АСУУДЛУУД

1. Эмнэлэг, сургууль болон бусад төрийн үйлчилгээ авахын тулд үүсч буй өрхүүд

2. Утаагүй зуух, гоожингийн эрх хөнгөлөлттэй үнээр авахын тулд үүсч буй өрх

Нэг өрх

Хүүхдүүд нь сургуульд ороод эхнэр нь хүүхэдтэйгээ сумын төвд амьдарч байгаа.

Нөхөр нь том хүүтэйгээ хөдөө амьдардаг.



Шийдэл:

- Сум, баг, хороо дотроо - Нэг өрх
- Хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэл хооронд - Хоёр өрх

# ЭЦЭГ/ ЭХИЙН НЭР, ӨӨРИЙН НЭР / санд/

Өрхийн гишүүний бүртгэлийг хийхдээ хамгийн эхэнд дараах мэдээллийг оруулах;

- Эцэг/эхийн нэр;
- Өөрийн нэр;
- Регистрийн дугаар;

Эдгээрийн албан ёсны бичиг баримтан дээрхээс зөрүүлэхгүй байхыг хариулагчид анхааруулах

# ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХАМААРАЛ

- Тухайн өрхийн тэргүүлэгчийн хувьд харгалзах хамаарлыг сонгох;
  - Шинээр бүртгүүлж байгаа өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болохыг асууж шинэчлэхийг анхааруулах;

# ХАЯГИЙН ХЭСЭГ

# ХАРГАЛЗАХ НЭР, КОДЫГ БӨГЛӨХ

**ӨРХИЙН БҮРТГЭЛИЙН ДУГААР:**

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | |

**I (A). ХАЯГИЙН ХЭСЭГ**

Бүртгэсэн он: 2 0 1 5

| | | |
|---|---|---|
| А1. Аймаг, нийслэлийн нэр, код | | |
| А2. Сум, дүүргийн нэр, код | | |
| А3. Баг, хорооны нэр, код | | |
| А4. Хэсэг | | |

Гудамжны нэр:

Байшингийн дугаар:

Орц:

Хашаа/ хаалганы дугаар:

Холбоо барих утасны дугаар:

# ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ҮНДСЭН БҮРТГЭЛ

# ЭЦЭГ/ ЭХИЙН НЭР, ӨӨРИЙН НЭР

Өрхийн гишүүний бүртгэлийг хийхдээ хамгийн эхэнд дараах мэдээллийг нөхнө;

- Ургийн овог;
- Эцэг/эхийн нэр;
- Өөрийн нэр;
- Регистрийн дугаар;
- Хүйс;
- Яс үндэс;




Эдгээрийг албан ёсны бичиг баримт дээрхээс зөрүүлэхгүй байхыг хариулагчид анхааруулах;

**II (А). ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ҮНДСЭН БҮРТГЭЛ**

| № | (Өрхийн тэргүүлэгчээс эхлэн бүх гишүүнийг бичнэ) | | ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХАМААРАЛ | ХҮЙС: эрэгтэй -1, эмэгтэй - 2 | ЯС ҮНДЭС | РЕГИСТРИЙН ДУГААР |
|---|---|---|---|---|---|---|
| | УРГИЙН ОВОГ | ЭЦЭГ/ ЭХИЙН НЭР, ӨӨРИЙН НЭР | | | | |
| А | А1 | А2 | А3 | А4 | А5 | А6 |
| 01 | | | | | | РД |

# ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХАМААРАЛ

- Тухайн өрхийн тэргүүлэгчийн хувьд харгалзах хамаарлыг сонгох;
  - Шинээр бүртгүүлж байгаа өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болохыг асууж шинэчлэхийг анхаарах;

А3. ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХАМААРАЛ

| | |
|---|---|
| Өрхийн тэргүүлэгч ................ | 01 |
| Эхнэр/ нөхөр ............................ | 02 |
| Хүү/ охин .................................. | 03 |
| Эцэг/ эх ..................................... | 04 |
| Ах/ эгч/ дүү ............................... | 05 |
| Хадам эцэг/ эх .......................... | 06 |
| Хүргэн/ бэр ................................ | 07 |
| Өвөг эцэг/ эмэг эх .................... | 08 |
| Ач/ зээ ........................................ | 09 |
| Бусад хамаатан ........................ | 10 |
| Хамааралгүй .............................. | 11 |



# ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХАМААРАЛ

- ***Өрхийн тэргүүлэгч;*** Байнга оршин суугч, 16, түүнээс дээш насны, тухайн өрхийн орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлж байгаа хүнийг;
- ***Эхнэр/ нөхөр.*** Гэрлэсэн буюу хамтран амьдарч буй харилцан тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх эмэгтэй, эрэгтэй хүмүүс;
- ***Хүү/ охин.*** Төрүүлсэн болон дагавар, өргөмөл хүү, охин;
- ***Эцэг/ эх.*** Төрсөн, хойт эцэг, эх;
- ***Ах/ эгч/ дүү.*** Төрсөн болон хойт эцэг, эхийн хүүхэд, өргөмөл ах, эгч, дүүг;
- ***Хадам эцэг/ эх.*** Өрхийн тэргүүлэгчийн эхнэр/ нөхрийн төрсөн, өргөж авсан болон хойт эцэг, эхийг;

# ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХАМААРАЛ

- ***Хадам эцэг/ эх***. Өрхийн тэргүүлэгчийн эхнэр/ нөхрийн төрсөн, өргөж авсан болон хойт эцэг, эх;
- ***Хүргэн/ бэр.*** Төрсөн болон өргөмөл, дагавар хүү/ охины нөхөр/ эхнэр;
- ***Өвөг эцэг/ эмэг эх***. Өрхийн тэргүүлэгчийн эмээ, өвөөг,
- ***Ач/ зээ.*** Төрсөн болон өргөмөл, дагавар хүү, охины хүүхэд;
- ***Бусад төрөл төрөгсөд***. Өрхийн тэргүүлэгчийн өөрийн авга, нагац хамаатнууд болон эхнэр/ нөхрийн авга, нагац хамаатнууд, тэдгээрийн эхнэр/ нөхөр, хүүхэд, ах, эгч, дүү, эмээ, өвөө;
- ***Хамааралгүй.*** Өрхийн тэргүүлэгчтэй ураг төрлийн болон гэр бүлийн ямар нэг хамааралгүй, тусдаа өрх үүсгээгүй хүмүүс;

# СУУРЬШИЛ

- **Байнгын оршин суугч:** Тухайн засаг захиргааны нэгжид 6 сар /183 хоног/, түүнээс дээш буюу хугацаагаар оршин суугаа хүн;
- **Түр эзгүй оршин суугч:** Байнгын оршин сууж байсан газраасаа 183 хоног, түүнээс дээш хугацаагаар цэрэгт явсан, сургуульд явсан, гадаад явсан, бусад тохиолдолоор явсан зэрэг шалтгаанаар “Түр эзгүй” байгаа бол энэ ангилалд орно. Эдгээр хүмүүс нь байнга сууж байгаа газартаа “Түр суугаа” гэж байх ёстой.
- **Түр суугаа оршин суугч:** Өөр засаг захиргааны нэгжээс ирж, тухайн засаг захиргааны нэгжид 6 сар (183 хоног)-аас доош хугацаагаар сууж байгаа хүмүүсийг “Түр суугаа” гэж үзнэ.

# СӨБ, СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТЫН ТҮВШИН



- Энэ асуултыг 2-39 насны хүнээс асууж, хариултыг нөхнө.

- ***Хамрагдаагүй:*** Энэ ангилалд тухайн хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн аль нэг ангид сурч байгаад дахин суралцаагүй, сургуулиа орхисон хүүхдийг сургууль завсардсан, сургууль төгссөн болон гэртэй байх зэргээс үл хамааран тухайн цаг хугацаанд СӨБ сургуульд хамрагдаагүй хүмүүсийг авч үзнэ.

А10. СӨБ, СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТЫН БАЙДАЛ (2-39 нас)

*дотоод*

*ЕБС ................................ 11*
*ТМБСБ ........................ 12*
*Их, дээд сургууль .....13*
*СӨБ ............................ 14*
*Хамрагдаагүй........... 15*

*гадаад*

*ЕБС ................................ 21*
*ТМБСБ ........................ 22*
*Их, дээд сургууль..... 23*

# ХҮН АМЫН ТӨЛӨВ

Энэ хэсгийг бүх хүнээс асууж харгалзах ангиллыг бөглөнө.

- **Тухайн хаягт оршин суугч**- Албан ёсны шилжүүлэгтэй/шилжүүлэггүй эсэхээс үл хамааран тухайн хаягт амьдарч байгаа хүнийг бүртгэнэ.
- **Гадаадад оршин суугч**- 183 хоногоос дээш хугацаагаар гадаад явсан хүнийг хамруулна. 183 хоногоос доош хугацаагаар гадаад явсан тохиолдолд тухайн хаягт ошин суугч гэсэн ангилалд орно.

# БОЛОВСРОЛЫН ТҮВШИН



## 6, түүнээс дээш настай бүх хүнээс асуух

- **Тийм** гэж хариулсан тохиолдолд эзэмшсэн болосролын дээд түвшинг тодруулан асууж тохирох хариултыг сонгох;

| Боловсролын түвшин / Он | Боловсролгүй | Бага | Суурь (Бүрэн бус дунд) | Бүрэн дунд |
|---|---|---|---|---|
| **1975 хүртэлх онуудад** | 4-р ангийг төгсөөгүй. | 4-р анги төгссөн. | 7-р анги төгссөн. | 10-р анги төгссөн. |
| **1975-1996 онуудад** | 3-р ангийг төгсөөгүй. | 3-р анги төгссөн. | 8-р анги төгссөн. | 10-р анги төгссөн. |
| **1997-2004 онуудад** | 4-р ангийг төгсөөгүй. | 4-р анги төгссөн. | 8-р анги төгссөн. | 10-р анги төгссөн. |
| **2005 онд** | 5-р ангийг төгсөөгүй. | 5-р анги төгссөн. | 9-р анги төгссөн. | 10-р анги төгссөн. |
| **2006 ба түүнээс хойшхи онуудад** | 5-р ангийг төгсөөгүй. | 5-р анги төгссөн. | 9-р анги төгссөн. | 11-р анги төгссөн. |

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭСЭХ

- Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг нь сайтар лавлан асууж кодыг харгалзах нөхнө.

А11. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭСЭХ

*Хөгжлийн бэрхшээлгүй ....*
*Хөгжлийн бэрхшээлтэй:*

| | төрөлхийн | олдмол |
|---|---|---|
| Харааны ............. | 21 | ...... 31 |
| Ярианы ............... | 22 | ...... 32 |
| Сонсголын .......... | 23 | ...... 33 |
| Хөдөлгөөний ...... | 24 | ...... 34 |
| Сэтгэцийн.......... | 25 | ...... 35 |
| Хавсарсан........... | 26 | ...... 36 |
| Бусад ................... | 27 | |

# ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ЭСЭХ



| ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ЭСЭХ: ТИЙМ -1, ҮГҮЙ - 2 /6, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАС/ | 15, түүнээс дээш нас | | |
|---|---|---|---|
| | ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ | ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГГҮЙ ШАЛТГААН | ОРЛОГЫН ХЭЛБЭР |
| A13 | A14 | A15 | A16 |

- 15, түүнээс дээш насны бүх хүнээс асуух;
- Сүүлийн 7 хоногт ядаж нэг өдөр цалин, орлоготой ажил эрхэлсэн эсэхээр тодруулж асуух;
  - **Тийм** гэж хариулсан бол асуултыг үргэлжлүүлэх;
  - **Үгүй** гэж хариулсан бол орлогын хэлбэр асуулт руу шууд шилжих;

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ



- 15, түүнээс дээш насны бүх хүнээс асуух;
- Хөдөлмөр эрхэлдэг эсэх? Гэсэн асуултад ТИЙМ гэж хариулсан тохиолдолд бөглөгдөнө.

А14. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

*Цалин хөлстэй ажиллагч* ............................ 1
*Ажил олгогч* .................................................... 2
*Хувиараа хөдөлмөр эрхлэгч* ........................ 3
*Нөхөрлөл, хоршооны гишүүн* ...................... 4
*Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч* ............................... 5
*Бусад* ............................................................... 6

# ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГГҮЙ ШАЛТГААН



- 15, түүнээс дээш насны бүх хүнээс асуух;
- Хөдөлмөр эрхэлдэг эсэх? Гэсэн асуултад **ҮГҮЙ** гэж хариулсан тохиолдолд бөглөгдөнө.

А15. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГГҮЙ ШАЛТГААН

*Сургуульд сурдаг* .......... 1
*Тэтгэвэрт* .......... 2
*Хөдөлмөр эрхлэх чадваргүй* .......... 3
*Гэрийн ажилтай* .......... 4
*Тохирох ажил олдохгүй байгаа* .......... 5
*Ажил хайж байгаа:*
  *ХХҮТ-д бүртгэлтэй* .......... 6
  *ХХҮТ-д бүртгэлгүй* .......... 7
*Ажиллах сонирхолгүй* .......... 8
*Бусад* .......... 9

# ОРЛОГЫН ХЭЛБЭР



A16. ОРЛОГЫН ХЭЛБЭР

| | |
|---|---|
| *Цалин хөлс* | 1 |
| *Тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговор* | 2 |
| *Мал аж ахуйн үйлдвэрлэлийн орлого* | 3 |
| *Газар тариалангийн үйлдвэрлэлийн орлого* | 4 |
| *ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого* | 5 |
| *Бусад орлого* | 6 |
| *Орлогогүй* | 7 |

- 15, түүнээс дээш насны бүх хүнээс асуух;
- Хэрэв орлогын 2 эх үүсвэртэй бол дийлэнх орлого олдог хэлбэрийг авах;

# НИЙГМИЙН ХАЛАМЖИД ХАМРАГДСАН БАЙДАЛ

- Тухайн иргэнээс нийгмийн халамж болон хүний хөгжил сангаас олгож буй хувь, хишигт хамрагдсан байдлыг асууж хариултыг сонгох;
  - Хэд хэдэн хариултыг сонгож болно.

А.17 НИЙГМИЙН ХАЛАМЖИД ХАМРАГДСАН БАЙДАЛ

*Нийгмийн халамжийн тэтгэвэр* ................................ a
*Нөхцөлт мөнгөн тэтгэмж* ........................................ b
*Өрх, иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламж* .............. c
*Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ* ................................................. d
*Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ* ................................ e
*Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт* ......... f
*Хүний хөгжлийн сангийн хишиг, хувь* ...................... g
*Бусад* ........................................................................ z

# ЦЭРГИЙН АЛБА ХААСАН ЭСЭХ.



- 18, түүнээс дээш насны эрэгтэйчүүдээс асуух;
  - Бүртгэл хийж байх үед цэргийн алба хааж байгаа хүнийг цэргийн алба хаагаагүйд тооцно.

| | |
|---|---|
| A18 | ЦЭРГИЙН АЛБА ХААСАН ЭСЭХ:<br>ТИЙМ - 1, ҮГҮЙ - 2<br>/ЗӨВХӨН 18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭРЭГТЭЙЧҮҮДЭЭС АСУУНА/ |

# СУУЦНЫ БҮРТГЭЛ

# СУУЦНЫ ҮЗҮҮЛЭЛТ

- Сууцны төрөл
- Эзэмшлийн хэлбэр
- Цахилгааны эх үүсвэр
- Усан хангамж
- Халаалтын эх үүсвэр
- Бохир ус зайлуулалт
- Хатуу хог, хаягдал зайлуулалт

# СУУЦНЫ БҮРТГЭЛ

- Бүртгүүлсэн өрх бүрээс сууцны үзүүлэлтүүдийг асууна.
  - Нэг сууцанд хамт амьдарч байгаа өрхүүдийн хувьд сууцны үзүүлэлтүүдийг салгаж бүртгэнэ.
- Өрх үүсгээгүй хүмүүсийн хувьд сууцны үзүүлэлтүүдийг нэгтгэж авна.
  - Нийтийн байрны сууцны үзүүлэлтүүдийг нэгтгэж бүртгэнэ.

# СУУЦНЫ БҮРТГЭЛ



Аав, ээж нь хоёр бага хүүхэдтэйгээ байшинд амьдардаг.



Гурван том хүүхэд нь тусдаа гэрт амьдардаг.

**Өрх:**

Хоёр ба түүнээс дээш тооны өөр төрлийн сууцанд амьдардаг бол:

- Ихэвчлэн амьдардаг буюу хоногийн ихэнх хугацаанд;
- Өрхийн тэргүүлэгчийн амьдардаг сууц;



Өрөөний тоо, талбайн хэмжээ, дэд бүтцийнх нь хангамжийг үндсэн сууцаар авна.

# СУУЦНЫ БҮРТГЭЛ

**Өрх:**

- Нэг хаяганд байгаа
- Зориулалтын зураг, төсөлгүй
- Сууцны ижил нөхцөлтэй
- Хувийн журмаар барьсан хоёр ба түүнээс дээш тооны сууцанд амьдардаг бол сууцыг бүхэлд нь үндсэн сууцаар авна.



Өрөөний тоо, талбайн хэмжээ, дэд бүтцийнх нь хангамжийг нэгтгэнэ.

# СУУЦНЫ ТӨРӨЛ

**Гэр**: Бүх төрлийн монгол гэр болон цаатны урц





**Байшин:** Нэг болон олон өрөөтэй, дээвэртэй, гадуураа ханатай, сууринаас дээвэр хүртэл ханаар хуваагдсан талбай бүхий орон байр

Суурцны төрөл:

B1. СУУЦНЫ ТӨРӨЛ

*Гэр* ........................................11

*Байшин:*

*Орон сууцны байшин* ..............21

*Бие даасан тохилог сууц* .......22

*Сууцны тусдаа байшин* ..........23

*Нийтийн байр* ..........................24

*Бусад сууц* ..................................31

# СУУЦНЫ ТӨРӨЛ



**Орон сууцны байшин:**

- Бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай,
- Бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй байгаа суурин барилгын доторх сууц

**Бие даасан тохилог сууц (хаус):** нэг өрх амьдрах зориулалтай байр



# СУУЦНЫ ТӨРӨЛ



Дэд бүтцийн бүх төрлийн хангамжтай:

- Цахилгаан, дулааны шугам болон усан хангамжийн сүлжээтэй;
- Сууцны дотор бие засах газартай;
- Сууцны дотор байрлуулсан онгоц, шүршүүртэй;
- Зориулалтын гал тогоо болон хоол хийх талбайтай



**Сууцны тусдаа байшин:**

- Ихэвчлэн гэр хорооллын хашаанд нэг ба түүнээс олон өрөөтэй,
- Дэд бүтцийн хангамжууд бүхэлдээ болон аль нэгээр хангагдаагүй сууц

# СУУЦНЫ ТӨРӨЛ

**Нийтийн байр:**

- Иргэд бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ амьдран суудаг,
- Олон өрөөтэй сууц



**Бусад сууц:**

- Анхнаасаа хүн амьдрах зориулалтаар бариагүй
- Хүн амьдрахад зориулан өөрчлөн засаж тохижуулсан сууц



Жишээлбэл, вагончик, амбаар, дэлгүүр, байшингийн дээвэр, хонгил, орц гэх мэт.

# ТАЛБАЙН ХЭМЖЭЭ/ХАНЫН ТОО

- Гэрт амьдардаг бол ханын тоо,
- Байшинд амьдардаг бол талбайн хэмжээг бичнэ.

Гэрийн ханын тоо 4, 5, 6, 8, 10, 12 болон байшингийн талбай хэмжээг 4-9999 м2 –ийн хооронд утга авна.



Талбайн хэмжээ(м.кв)/ханын тоо

| № | СУУЦНЫ НӨХЦӨЛ | Он 2015 |
|---|---|---|
| B1 | СУУЦНЫ ТӨРӨЛ ханын тоо/ талбайн хэмжээ ($м^2$) | |

# ТАЛБАЙН ХЭМЖЭЭ/ХАНЫН ТОО

Сууцны талбай нь хүн амьдрах болон туслах өрөө, тасалгааны талбайн нийлбэр юм.

Талбайн хэмжээ(м.кв)/ханын тоо — 65

**Хүн амьдрах талбай:**

- Амралтын (зочны);
- Унтлагын;
- Хүүхдийн;
- Мэргэжлийн болон ажлын;
- Хооллох өрөө

**Туслах өрөө, тасалгаа:**

- Гал тогооны;
- Угаалгын;
- Бие засах өрөө;
- Хонгил;
- Ханын шүүгээ;
- Агуулах



# ТАЛБАЙН ХЭМЖЭЭ/ХАНЫН ТОО

- Сууцны талбайн хэмжээг мэдэхгүй бол:
  - Сууц эзэмшигчийн гэрээ;
  - Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
  - Талбайг хэмжүүлэх
- Сууцны талбайн хэмжээ бутархай тоо бол бүхэлчлэх;

# ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР

**Өөрийн:**

- Сууцаа хувьчилж авсан
- Худалдаж авсан, өөрөө барьсан сууц



**Бусдын сууцанд түрээстэй суудаг:**

- Төрийн
- Хувийн ААНБ-ын
- Бусдын хувийн өмчийн сууцыг түрээслэн амьдарч байгаа өрх, хүн амын сууц

**Бусдын сууцанд түрээсгүй суудаг**

- Төрийн
- Хувийн ААНБ-йн
- Бусдын хувийн өмчийн сууцанд түрээсийн төлбөр төлөхгүйгээр амьдарч байгаа өрх, хүн амын сууц

Эзэмшлийн хэлбэр:

B2. ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР

*Өөрийн* ............................................*1*

*Бусдын сууцанд:*

*түрээстэй* .................................*2*

*түрээсгүй* .................................*3*

# ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР



**Төвлөрсөн систем**: Улсын цахилгаан болон усан станцаас цахилгаанаа авдаг сууц

**Дизель станц**: Тусгайлан барьсан болон орон нутгийн бие даасан дизель станцтай холбогдсон сууц

Цахилгааны эх үүсвэр:

В3. ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР

*Төвлөрсөн систем ........................1*
*Дизель станц ...............................2*
*Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж ....................................3*
*Бага оврын цахилгаан үүсгүүр ...4*
*Цахилгааны эх үүсвэргүй ...........5*

# ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР

PresenterMedia



Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж: Нар, салхины эрчим хүчийг хуримтлуулан цахилгаан эрчим хүч болгодог төхөөрөмж



Бага оврын цахилгаан үүсгүүр: Шатах болон бусад материалаар ажилладаг бага оврын мотор, цахилгаан үүсгүүр





Ямар нэг цахилгаан эрчим хүчний эх үүсвэргүй

# УСАН ХАНГАМЖ



**Төвлөрсөн усан хангамж:** Орон сууцны байшин, бие даасан тохилог сууц, нийтийн байр болон бусад байранд төвлөрсөн байдлаар ус түгээж байгаа систем

- Халуун, хүйтэн устай
- Хүйтэн устай

Усан хангамж:

B4. УСАН ХАНГАМЖ

| | Халуун, хүйтэн устай | Хүйтэн устай |
|---|---|---|
| *Төвлөрсөн усан хангамж* ... | *11* | .....*21* |
| *Бие даасан систем* ............ | *12* | .....*22* |
| *Зөөврийн* ............................... | | .....*23* |

# УСАН ХАНГАМЖ



**Бие даасан систем:** Тухайн сууцны хэрэгцээг хангах зорилгоор суурилуулсан бага хэмжээний, бие даасан байдлаар ус түгээж байгаа систем

**Зөөврийн:** Усны машинаар зөөвөрлөдөг, ус түгээх байр, гүний худаг, гол, мөрөн, нуур зэрэг гадаргуугаас усаа авдаг



# ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР



**Төвлөрсөн систем:** Дулааны цахилгаан станц, уурын зуухтай холбогдсон дулааны сүлжээтэй сууц

**Нам даралтын зуух:** Нэг болон хэсэг өрхийн хэрэгцээг хангах үүднээс нэгдсэн халаалтын сүлжээнд ашиглаж буй бага оврын зуух



Халаалтын эх үүсвэр:

B5. ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР

*Төвлөрсөн систем ........................1*
*Нам даралтын зуух .......................2*
*Цахилгаан халаагуур ....................3*
*Ердийн галлагаа ...........................4*

# ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР



**Цахилгаан халаагуур:** Цахилгаан эрчим хүчээр ажилладаг халаах төхөөрөмж

**Ердийн галлагаа:** Энгийнээр галлаж, халаадаг зуух, пийшинтэй бол ердийн галлагаатай



# БОХИР УС ЗАЙЛУУЛАЛТ

**Төвлөрсөн систем:** Төвлөрсөн байдлаар бохир ус зайлуулдаг систем



**Бие даасан систем:** Бохир ус зайлуулах бага хэмжээний системийг хэлнэ.

Бохир ус зайлуулалт:

B6. БОХИР УС ЗАЙЛУУЛАЛТ

*Төвлөрсөн систем* ........................ 1
*Бие даасан систем* ...................... 2
*Цооног* ........................................ 3
*Задгай* ......................................... 4

# БОХИР УС ЗАЙЛУУЛАЛТ

**Цооног:** Муу усны зориулалтын цооног болон жорлонгийн нүхэнд бохир усаа асгаж зайлуулах

**Задгай:** Тусгайлан зориулсан цооноггүй, задгай газарт бохир усаа асгадаг болон зөөх, булах гэх мэт гар аргаар бохир зайлуулалт



# ХАТУУ ХОГ, ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТ

**Үйлчилгээний байгууллагаар:** Тохижилт, үйлчилгээний байгууллага эсвэл бусадтай (хог ачигчтай) гэрээ хийж зайлуулдаг.

- Тогтмол
- Тогтмол бус хугацаагаар






**Зөвшөөрөгдсөн цэгт:** Нийтийн хогийн газар болон тодорхой төвлөрсөн цэгт зайлуулдаг.

Хатуу хог, хаягдал зайлуулалт:

В7. ХАТУУ ХОГ, ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТ

*Үйлчилгээний байгууллагаар* ..... 1
*Зөвшөөрөгдсөн цэгт* .................. 2
*Тогтсон цэг байхгүй* .................. 3

**Тогтсон цэг байхгүй:** Тухайн өрх айл хог зайлуулах тодорхой газаргүй, хогоо ил задгай хаядаг, булдаг, шатаадаг.



# ӨРХИЙН АЖ АХУЙ

# ӨРХИЙН АЖ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- Мал, тэжээвэр амьтантай эсэх
- Газар тариалан эрхэлдэг эсэх
- Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг эсэх
- Тээврийн хэрэгсэлтэй эсэх
- Компьютертэй эсэх
- Интернэттэй эсэх

# МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТАНТАЙ ӨРХ

## Мал, тэжээвэр амьтантай эсэх:






**Мал бүхий өрх**:

- Малаа маллаж, ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх
- Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

**Малчин өрх:** Малаа маллаж, ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрх



**Тэжээвэр амьтан:** Гахай, шувуу (тахиа, галуу), цаа буга, илжиг, зөгий туулай зэрэг үр ашгаа өгдөг амьтдыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх.

# МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТАН

Бусдын малыг маллаж зөвхөн ажлын хөлс авч, малынхаа ашиг шимийг эзэнд нь өгдөг бол **малчин өрхөд** хамруулахгүй.





Сумын төвд багш, эмч гэх мэт ажил хийдэг боловч малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг бол **мал бүхий** өрхөд хамруулна.

# ГАЗАР ТАРИАЛАН



Газар тариаланг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй эрхэлдэг болон газар тариалангийн бүтээгдэхүүн тэдний амьжиргааны үндсэн эх үүсвэр нь болж буй өрх

Тариалангийн талбайн хэмжээг метр квадрат ($м^2$)-аар тодорхойлж **4-99999 $м^2$ -ийн хооронд утга авна.** Жишээ нь: 1 сот = 100 метр квадрат

1 га = 10000 метр квадрат

Газар тариалан эрхэлдэг эсэх: — Тийм / Үгүй

Талбайн хэмжээ (m2): — 350

# ГАЗАР ТАРИАЛАН




Хүлэмжийн талбайг тариалсан талбайд оруулна. Тариалан эрхэлдэг өрхөд орон сууцны тагт болон гэрийн нөхцөлд сонгино, сармис, улаан лооль, өргөст хэмх зэрэг хүнсний ногоог бага хэмжээгээр тарьж, хэрэглэдэг өрхийг хамруулахгүй.

# ГАЗАР ТАРИАЛАН



Бусдын эзэмшил газарт тариалалт хийж, зөвхөн ажлын хөлс авч, хураасан ургацаа талбай эзэмшигчид өгдөг бол уг өрх **газар тариалан эрхэлдэг өрхөд хамруулахгүй.**

Газар тариалан эрхэлж байгаа өрх нь өөрийн газаргүй боловч бусдын газрыг түрээслэн тариалж, ашиг шимийг нь өөрөө хүртдэг бол тухайн өрхийг **газар тариалан эрхэлдэг** өрх гэж үзнэ.



# ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ



***Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг***: Эзэмшлийн хэлбэр харгалзахгүйгээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж орлого олдог өрхийг хамруулна.

***Хөрөнгө түрээслүүлдэг***: Өөрийн эзэмшлийн газар, байр, талбайг түрээслүүлэн орлого олдог өрхийг хамруулна.

Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг эсэх:

C3. ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛДЭГ ЭСЭХ:

*Тийм:*

*үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг ........................................1*

*хөрөнгө түрээслүүлдэг ............2*

*Үгүй ................................................3*

# ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Наад захын хэрэгцээндээ, эсвэл хэрэгцээтэй үедээ ашиглаж байгаа өрхийн өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгсэл



Тээврийн хэрэгсэлтэй эсэх:



C4. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛТЭЙ ЭСЭХ:

*Тийм: суудлын ................................a*
*ачааны ................................b*
*автобус ................................c*
*мотоцикл ...........................d*
*тусгай зориулалтын ...... e*
*Үгүй ................................................z*

# КОМПЬЮТЕР





Хүний өдөр тутмын хэрэглээнд зориулагдсан персональ болон зөөврийн компьютер /нөтбүүк/, Айпад /Ipad/-ын аль нэг нь өрх

Компьютертэй эсэх:

Тийм
Үгүй

# ИНТЕРНЭТ



Телефон утас болон түрээсийн шугам, өндөр хурдны хэрэглэгчийн тоон шугам (ДиСЛ, ЭйДиСЛ), байнгын гарцтай, өндөр хурдны кабель модем, шилэн кабелиар интернэтэд холбогдсон өрх

Интернэттэй эсэх:

Тийм
Үгүй

# Анхаарал хандуулсанд баярлалаа

www.statis.mn/portal
www.nso.mn
Phone-70582879
70584240

dstatistic@yahoo.com

СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН
www.1212.mn
ЛАВЛАХ УТАС:
1212
Даваа - Баасан
08:00 - 12:00
13:00 - 17:00